

Өвөрхангай аймгийн танилцуулга

Нэг. Нийгмийн хөгжил

Өвөрхангай аймаг БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 07-ны өдрийн тогтоолоор 31 сумтай байгуулагдсан. Эдүгээ засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 103 багтай, 2005 оны жилийн эцсийн байдлаар 28.8 мянган өрх, 108.2 мянган хүн амтай. Аймгийн төв Арвайхээр хотод 23.8 мянган хүн оршин суудаг.

Монголын анхдугаар богд төр, шашин, соёлын нэрт зүтгэлтэн Өндөр гэгээн Занабазар, Богд хаант Монгол Улсын ерөнхий сайд, сайн ноён хан Намнансүрэн, Монгол Улсын ерөнхий сайд П.Гэндэн нарын түүхэнд мөнхөрсөн олон суутнууд Өвөрхангай аймгийн нутагт төрсөн. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, чөлөөт бөхийн дэлхийн хошой аварга З.Ойдов, Монгол Улсын дархан аварга, гавьяат тамирчин Д.Цэрэнтогтох, Монгол улсын Ардын уран зохиолч Д.Пүрэвдорж, Доктор, профессор Чой. Лувсанжав нарын зэрэг олон алдартнаараа Өвөрхангайчууд бахархдаг.

Тус аймагт дээд сургууль 2, хүүхдийн цэцэрлэг 28 ажиллаж, ерөнхий болосролын 28 сургуулийн 703 бүлэгт 24221 хүүхэд суралцаж, боловсролын салбарт 1446 багш ажилтан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд БОЭТөв-1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-1, сум дундын эмнэлэг- 1, сумын эмнэлэг-16, их эмчийн салбар -2, бага эмчийн салбар-61, эмийн сан 23 ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт их эмч 170, эмийн дээд мэргэжилтэн 10, эмнэлгийн дунд мэргэжилтэн 490, нийт 1014 хүн ажиллаж байна. Аймгийн хүн амд 20 орчим төрлийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлж, нэг их эмчид 636 хүн ноогдож, нэг иргэн жилд дунджаар 2.3 удаа эмнэлэгт үзүүлж байна.

19 суманд соёлын өргөө, 18 суманд номын сан, Арвайхээрт ХДТ, музей, номын сан, кинотеатр ажиллаж байна.

Хоёр. Байгаль орчин

Өвөрхангай аймаг 63.5 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, хойноос урагшаа 385 км, зүүнээс баруун хил хүртэл 310 км үргэлжилнэ. Монгол улсын газар зүйн хүйс төв цэг нь тус аймгийн Бүрд сумын Өвөрхөшөөтийн булгийн дэргэд байдаг. Тус аймаг үзэсгэлэн төгөлдөр байгальтай. Нутгийн хойд хэсэгт Хангайн нурууны салбар уулс, төв хэсгээр нь хөндийн тал, өмнө хэсгээр нь Алтай нурууны салбар уулс, элсэрхэг тал хээрийн нутагтай. Тус аймгийн нутгийн 23.0 хувь нь хангайн, 28.2 хувь нь тал хээрийн, 48.8 хувь нь говийн бүсэд хамаарагддаг. Жилийн дундаж температур +1.2 С/хэм/ бөгөөд эрс тэс уур амьсгалтай, жилд дунджаар 198.8 мм хур тунадас бууна.

Тус аймгийн нутаг газар зүйн 3 бүсийг хамрах тул байгалийн үлэмж баялагтай. Нутгийн 3.4 хувь буюу 211.8 мянган га талбайг 17.5 сая шоометр нөөц бүхий шилмүүст болон навчит, заган ой эзэлдэг. Тус аймгийн нутагт Хангайн нурууны Хятруун, Битүүт, Монгол Алтайн нурууны Багабогд, Мянган ямаат зэрэг далайн түвшнээс дээш 2000-3590 м өндөрт өргөгдсөн сүрлэг уул, нурууд оршдог. Мөн 24 метрийн өндрөөс буух Орхон голын ***Улаан цутгалан***, далайн түвшнээс дээш 2500 метрийн өндөрт орших байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт **Хүйсийн найман нуур** болон ***Тамчийн хавцал*** зэрэг сонин сайхнаараа гайхагдсан газар тус аймагт олон байдаг. **Арвайхээр, Шагж, Долоодой, Хонгор, Гучингийн тал** болон Орхоны хөндий зэрэг тэгш удам талууд, Онги, Таац, Орхон, Ар агуй зэрэг голууд тус аймгийн нутагт бий.

Анагаах, эдгээх чадалтай ар, өвөр Хятруун, Хамар могойт, Таац, Мөст, Хүрэн хад, Тахь, Хорхой түрүү, Хүрэмт зэрэг халуун, хүйтэн, том, жижиг олон рашаантай. Эдгээрээс хамгийн алдартай нь Хужиртын рашаан юм.

Хангайд буга, бор гөрөөс, тал хээрт үнэг, чоно, хярс, мануул, говьд аргаль, янгир, цагаан зээр, хар сүүлт, хойлог зэрэг ан амьтан элбэгтэй бөгөөд дэлхийн улаан номонд бичигдсэн дархан цаазат хулан, ирвэс ч байдаг.

Аймгийн бүх нутаг дэвсгэрт геологи хайгуулын 1:200000 -ны зураглал хийгдсэн ба нутгийн 20 гаруй хувьд 1: 100000-ны , 10 шахам хувьд 1 :50000-ны зураглал хийгдсэн нь ашигт малтмалын нөөц нэлээд сайн судлагдсан аймаг юм. Геологи, хайгуулын судалгааны материалаас үзэхэд тус аймгийн нутагт сул шороон алтны 4 орд, 10 илрэл, ховор металлын 9, өнгөт болон холимог металлын 4, төмрийн 2, эрдэс будгийн 4, барилгын материалын 12, давсны 1 ордны илрэл байна.

Одоо Уянга сумын Баруун сөдтэйн алтны ордод ашиглалт, нарийвчилсан хайгуул, Бат-Өлзий сумын Зүүн Сөдтэй, Тарагт сумын Хуурай сайр, Баян-Өндөр сумын Хөшөөт, Зүүнбаян-Улаан сумын Шивээт зэрэг газруудад алтны эрэл, үнэлгээний хайгуулын ажил хийгдэн зарим газарт үйл ажиллагаагаа хийгдэж байна. Хужирт, Зүүнбаян-Улаан, Богд, Өлзийт, Төгрөг, Баруунбаян-Улаан сумын нутагт вольфрам, молибден зэрэг ховор металлын, Сант Гучин-Ус, Баянгол сумдын нутагт зэсийн, Төгрөг, Богд сумын нутагт төмрийн, Богд, Баруунбаян-Улаан, Уянга, Хархорин, Тарагт, Есөнзүйл сумдын нутагт гоёл чимэглэлийн чулууны, Богд, Баруунбаян-Улаан суманд хүрэн нүүрсний орд, илрэл байна. Мөн Богд Хархорин суманд битум, Богд, Төгрөг суманд эрдэс будгийн түүхий эдийн илрэл байгаа бөгөөд барилгын бүх төрлийн түүхий эд нэлээд суманд тархсан нь судлагдсан байна.

Тус аймгийн нутагт улсын тусгай хамгаалалтын **Хангайн нурууны байгалийн цогцолбор газар**, **Бүрд сумын Монгол элсний орчим нутаг Хөгнө Тарнийн**

байгалийн цогцолбор газар Хүйсийн найман нуур, Батхаан уул зэрэг тусгай хамгаалалттай газрын хэмжээ 297.3 мянган га болж, нийт нутаг дэвсгэрийн 4.7 хувийг эзэлдэг.

Тус аймгийн нутаг эртний хүний амьдралын ул мөр, чулуун зэвсгийн үеийн дарханы газруудын үлдэц, манай тооллын эхэн ба өмнөх хүрлийн үеийн бунхан, бичигт хад зэрэг түүх соёлын дурсгалт зүйлсээр баян юм. Уянга сумын нутаг дахь түрэг бичээс бүхий Онгийн хөшөө нь НҮБ-ын хамгаалалтад орсон юм. XIII зууны Монголын анхны нийслэл Хархорины туурь, XVI зууны сүүлчээр байгуулсан Эрдэнэзуу хийгээд эртний болон дундад зууны үеийн Монголын түүх, соёлын дурсгалт газрууд бий.

Гурав. Эдийн засгийн хөгжил

Өвөрхангай аймаг ХАА голлосон эдийн засагтай. 2005 онд таван төрлийн 2301.1 мянган толгой малтай болж, мал сүргийнхээ тоогоор улсад хоёрт орсон.

Тус аймаг эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн бөгөөд Арвайхээр-Улаанбаатар, Хархорин-Улаанбаатар хотын хооронд цардмал зам тавигдсан. Аймгийн холбооны газар Норвеги улсын тоног төхөөрөмж болох тоон дамжуулах радио релейний шугамтай бөгөөд 1997 онд Герман улсын тоног төхөөрөмжөөр 1700 номер бүхий тоон дамжуулах автомат телефон станц тавьж, өргөтгөл хийжээ. 2003 онд Хужирт, Хархорин суманд ХАЙКОМ- АТС, 2005 онд Уянга суманд СИ-ЭС 1000 тоон АТС дамжуулах релейний станцтай тавьж өргөтгөл хийгдсэн. Арвайхээр, Хужирт, Хархорин суманд Мобикомын салбар, Уянга суманд Скайтелийн салбар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. Тус аймгийн 16 сум төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон.

Өвөрхангай аймагт хувьцаат компани 19, хязгаарладмал хариуцлагатай компани 201, хоршоо 105, нөхөрлөл 75, УҮГ 7 ажиллаж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд 2005 онд 27.8 тэрбум төгрөгийн бүтээгдхүүн үйлдвэрлэсний 70.0 хувийг хөдөө аж ахуйн салбарын бүтээгдхүүн үйлдвэрлэлт 3.2 хувийг үйлдвэрийн салбарын бүтээгдхүүн үйлдвэрлэл, 26.8 хувийг үйлчилгээний салбарын бүтээгдхүүн үйлдвэрлэлт тус тус эзэлж байна. Аймгийн нэг хүнд 255100 төгрөгийн бүтээгдхүүн ноогдож байна. Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд жилд дунджаар 1454.4-1700.0 сая. төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1426.0-1800.0 орчим сая. төгрөгийн борлуулалт хийж байна. Үүний 45.7 хувийг хүнсний, 22.7 хувийг цахилгаан дулааны, 20.5 хувийг нүүрсний, 11.1 хувийг бусад жижиг үйлдвэрлэлийн бүтээгдхүүн тус тус эзэлж байна.

Барилгын чиглэлийн аж ахуйн нэгжүүд барилгын үйл ажиллагаа эрхлэх материаллаг бааз, ажиллах хүчний бүрэн боломжтой. 2005 онд аймгийн хэмжээнд 1106.9

сая.төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэний 678.6 сая.төгрөгийн барилга угсралт их засварын ажлыг аймгийн барилгын чиглэлийн аж ахуйн нэгжүүд гүйцэтгэсэн.

Тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 11.4 мян.т ачаа, 99.2 мянган хүн тээвэрлэж, худалдааны чиглэлийн аж ахуйн нэгж, цэг салбарууд жилд 2650.0-2747.8 сая төгрөгийн бараа борлуулалт хийж байна.

Тус аймагт жилдээ 36.0 мянган тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай Хархорин дахь /Гантээрэм ХК/ гурилын үйлдвэр, 150 мянган тн нүүрс гаргах чадалтай /Баянтээг ХК/ нүүрсний уурхайтай.

МАА-гаас гарах бүтээгдэхүүнийг дунджаар тооцоход хонины ноос 1270.0 тн, тэмээний ноос 70.9 тн, ноолуур 286.2 тн, бодын хөөвөр 89.0 тн, бодын хялгас 58.0 тн-ыг тус тус бэлтгэх ба ингэнээс 376.8 мянган литр, гүүнээс 4418.0 мянган литр, үнээнээс 6553.4 мянган литр, эм хониноос 2209.5 мянган литр, эм ямаанаас 3264.0 мянган литр сүүг саалийн хугацаанд ашиглах бололцоотой юм. Энэ нөхцөл, нөөц бололцоог түшиглэн мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэрүүд байгуулж хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

Байгалийн үзэсгэлэнт газар, зам харилцааны өргөн боломжийг түшиглэн байгуулсан улсын хэмжээнд томоохонд тооцогдох Хужирт сумын амралт, рашаан сувиллын газар, Баянговь, Хархорин суманд жуулчны баазууд ажилладаг юм.

